



БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2020 оны жилийн эцсийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668, e-mail: nbfi@frc.mn

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	3
Зургийн жагсаалт	3
Товчилсон нэрсийн жагсаалт.....	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	7
“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт	8
“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт	8
“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт ..	8
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	8
СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	9
Харилцагчид, зээлдэгчид	9
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид.....	9
Тархалт	11
АКТИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ.....	12
Мөнгөн хөрөнгө	13
Богино хугацаат хөрөнгө оруулалт	13
Факторингийн тооцооны авлага	14
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	14
Зээл	14
Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	16
Бусад хөрөнгө	16
Эргэлтийн бус хөрөнгө	17
ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ.....	18
Санхүүгийн эх үүсвэр	18
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг.....	19
Бусад эх үүсвэр.....	19
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	20
Төслийн зээлийн санхүүжилт	20
Бусад өр төлбөр.....	21
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	21
Бусад өмч, сангууд	22
Хуримтлагдсан ашиг	22
Хоёрдогч өглөг	23
АШИГТ АЖИЛЛАГАА.....	23
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	25
ДҮГНЭЛТ	26

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл.....	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/.....	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа.....	5
Хүснэгт 5 Харилцагчдын мэдээлэл.....	9
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	9
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл.....	9
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	10
Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт.....	11
Хүснэгт 10 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт.....	11
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/.....	12
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	13
Хүснэгт 15 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	13
Хүснэгт 16 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 17 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 18 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	14
Хүснэгт 19 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/.....	15
Хүснэгт 20 Аппликэйшн ашиглан зээл олгож байгаа ББСБ-ууд.....	16
Хүснэгт 23 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/.....	16
Хүснэгт 24 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	17
Хүснэгт 25 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/.....	18
Хүснэгт 26 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/.....	19
Хүснэгт 28 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/.....	19
Хүснэгт 29 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	19
Хүснэгт 31 ББСБ-аас гаргасан өрийн бичиг /сая төгрөгөөр/.....	20
Хүснэгт 33 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	20
Хүснэгт 34 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/.....	21
Хүснэгт 35 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/.....	21
Хүснэгт 36 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/.....	22
Хүснэгт 37 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 38 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/.....	22
Хүснэгт 40 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/.....	23
Хүснэгт 41 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/.....	24
Хүснэгт 42 2020 оны валют арилжааны мэдээ /тэрбум төгрөгөөр/.....	24
Хүснэгт 43 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	25

Зургийн жагсаалт

Зураг 1 ББСБ-уудын тархалт.....	11
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	12
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	13
Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/.....	15
Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/.....	15
Зураг 6 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	18
Зураг 7 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/.....	18
Зураг 8 Бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ-ууд /тэрбум төгрөгөөр/.....	19
Зураг 9 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	20
Зураг 10 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/.....	21
Зураг 11 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/.....	23

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

2020 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 532 ББСБ байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 6 ББСБ буюу 1.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 77 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 30 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2016	2017	2018	2019	2020
Шинээр олгосон	72	31	15	14	14
Хүчингүй	4	15	10	15	20
Түдгэлзүүлсэн	0	23	22	13	34
Сэргээсэн	1	8	7	9	9
Нийт ББСБ	518	534	539	538	532
Үүнээс: ХОН	60	70	73	75	77
Үүнээс: ГХО	30	27	29	27	30
Салбар	124	164	230	250	295
Төлөөлөгч	4	4	5	7	9

2020 оны жилийн эцсийн байдлаар 14 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 20 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 34 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 9 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2020 оны жилийн эцсийн байдлаар 15 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2019	2020	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1730.1	2006.9	16.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	4.8%	5.5%	0.7%
Нийт өөрийн хөрөнгө	1261.2	1450.7	15.0%
Банкны салбартай харьцуулахад хувиар	41.6%	47.4%	5.8%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	927.0	1017.7	9.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	120.6%	132.2%	11.6%
Нийт зээл	1233.1	1327.0	7.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	6.9%	7.5%	0.6%
Нийт орлого	352.9	408.8	15.8%
Нийт зарлага	212.7	254.0	19.4%
Цэвэр ашиг	140.2	154.8	10.4%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар өссөн бөгөөд энэ нь банкны салбарын нийт активын 5.5%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны банкнуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.3 дахин их байгаа нь ББСБ-ууд өөрийн хөрөнгөндөө тулгуурлан үйл ажиллагаа эрхэлдэгтэй холбоотой.

2020 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 16.0 хувиар буюу 276.8 тэрбум төгрөгөөр өсөж 2.0 их наяд төгрөгт хүрсэн. Активын өсөлтийн 46.1 хувийг мөнгөн хөрөнгийн өсөлт, 25.5 хувийг цэвэр зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 68.5 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 15.8 хувиар буюу 55.9 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 19.4 хувиар буюу 41.3 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 10.4 хувиар буюу 14.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2019	2020	тоо	хувь
	Нийт ББСБ-ын тоо	538	532	-6	-1.1%
1	Зээл	494	494	-	-
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	342	335	-7	-2.0%
2	Факторинг	29	34	5	17.2%
3	Төлбөрийн баталгаа гаргах	20	21	1	5.0%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	4	5	1	25.0%
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	31	34	3	9.7%
6	Гадаад валютын арилжаа	156	147	-9	-5.8%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	43	38	-5	-11.6%
7	Итгэлцэл	34	43	9	26.5%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	11	1	10.0%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	34	37	3	8.8%

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 532 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж

байна. Нийт ББСБ-уудын 92.9% нь буюу 494 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 63.0% нь буюу 335 ББСБ дагнан эрхэлж байна. Харин нийт ББСБ-уудын 27.6 хувийг буюу 147 ББСБ гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа байгаа ба дагнан эрхэлж байгаа 38 ББСБ нийт ББСБ-уудын 7.1% бүрдүүлж байна.

Зээл болон гадаад валют арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс харгалзан 2.0%, 11.6 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдэж байгаа нь ББСБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ тэлж байгааг харуулж байна. Харин нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл факторингийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар, итгэлцэлийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар өссөн байна.

2020 оны жилийн эцсийн тайлан мэдээний ирц 99.6% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 532 ББСБ-аас 530 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 2 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

ХУУЛЬ, ТОГТООМЖ БОЛОН ЖУРМЫН ӨӨРЧЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ

Банк бус санхүүгийн байгууллагын салбарт мөрдөгдөх дүрэм, журмуудыг хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах, шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд 2020 онд дараах дүрэм журмуудыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

- “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ыг боловсруулж, 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [370 дугаар тогтоолоор](#) батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4586 дугаараар бүртгүүлсэн.

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн батлах тухай” тогтоолыг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [441 дүгээр тогтоолоор](#) батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4622 дугаараар бүртгүүлсэн.

- “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам” батлах тухай тогтоолыг 2020 оны 01 дугаар сарын 15-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [10 дугаар тогтоолоор](#) батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4672 дугаараар бүртгүүлсэн.

- Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн [122/58 тоот хамтарсан тушаалаар](#) өөрчлөлт оруулж,

2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх түр хугацаанд хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлэсэн.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдөр 2015 оны “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаанд өөрчлөлт оруулах тухай [854 дүгээр тогтоолыг](#) баталж, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд мөрдөж ажиллуулахаар шийдвэрлэсэн.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн [998 дугаар тогтоолоор](#) “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан ба Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 4925 дугаарт бүртгэгдсэн.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 998 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д түр хугацаанд өөрчлөлт оруулах тухай [1020 дугаар тогтоолыг](#) баталж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд мөрдөж ажиллах шийдвэр гаргаад байна.

- Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-д 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн [148 дугаар тогтоолоор](#) өөрчлөлт оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулсан.

- “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулах тухай тогтоолыг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [352 дүгээр тогтоолоор](#) батлуулж, Захиргааны хэм хэмжээний

актын улсын нэгдсэн санд 2020 оны 7 дугаар сарын 28-ны өдөр хүлээн авсан.

- “Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг боловсруулж, 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, [495 дугаар тогтоолоор](#) батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4835 дугаараар бүртгүүлсэн.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2020 оны жилийн эцсийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 96.1% буюу 517 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 450 ББСБ хэрэгжүүлсэн байна.

“Зээлийн мэдээллийн тухай” хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээг байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүрэгтэй. Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 дугаар тушаалаар “Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журам”-ыг шинэчлэн баталсантай холбоотойгоор Монголбанкнаас мэдээлэл нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг нэгдсэн журмаар шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 494

ББСБ-ын 81.6% буюу 403 ББСБ гэрээгээ шинэчлэн байгуулсан байна.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 177 ББСБ, 9,950 удаагийн тохиолдлоор, 1.2 их наяд тэрбум төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 7 ББСБ, 84 удаагийн тохиолдлоор, 13.8 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 538 ББСБ-аас 1.2 тэрбум төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 85.7% буюу 456 ББСБ 1.0 тэрбум төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2020 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 8,869 хувь нийлүүлэгчдийн 532 ББСБ, 295 салбар нэгж, 9 төлөөлөгчийн газар, 3,437 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 2,844,782 харилцагч, 788,058 зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 4 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	2,844,782	546,383	329,633	2,515,149	40,450	2,827,531	17,251	366,498	64,418
Үүнээс: Эмэгтэй	1,494,739	296,202	173,946	1,320,793	21,162	1,484,333	10,406	202,583	32,883
Эрэгтэй	1,345,954	249,753	151,660	1,194,294	17,986	1,339,158	6,796	163,801	31,313
Хуулийн этгээд	4,089	428	4,027	62	1,302	4,040	49	114	222
Итгэмжлэгчдийн тоо	6,996	6,996	6,547	449	-	6,995	1	400	280
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	941	861	276	665	-	937	4	693	1
Зээлдэгчдийн тоо	788,058	413,644	215,390	572,668	-	771,267	16,791	236,701	64,407
Хэвийн	695,677	356,158	185,949	509,728	-	683,226	12,451	198,405	54,260
Хугацаа хэтэрсэн	40,274	18,737	14,495	25,779	-	37,165	3,109	10,896	3,691
Чанаргүй:	52,107	38,749	14,946	37,161	-	50,876	1,231	27,400	6,456
-Хэвийн бус	8,876	5,492	5,138	3,738	-	8,685	191	2,673	2,281
-Эргэлзээтэй	20,534	17,043	4,949	15,585	-	20,285	249	13,609	2,877
-Муу	22,697	16,214	4,859	17,838	-	21,906	791	11,118	1,298
Зээлдэгчдийн насжилт	786,491	413,268	213,878	572,613	-	769,749	16,742	236,594	64,187
18-35 насны	456,497	240,440	100,228	356,269	-	449,243	7,254	143,353	39,535
36-45 насны	200,657	109,788	66,498	134,159	-	195,396	5,261	57,778	14,126
46-55 насны	106,575	47,916	35,533	71,042	-	103,391	3,184	27,252	8,378
55-аас дээш	22,763	15,124	11,620	11,143	-	21,720	1,043	8,211	2,149
Зээлдэгчдийн боловсрол	786,452	413,268	213,839	572,613	-	769,710	16,742	236,594	64,147
-Дээд	523,431	234,309	129,547	393,884	-	514,463	8,968	144,266	43,169
-Тусгай дунд	65,843	35,449	29,192	36,651	-	62,748	3,095	11,490	9,379
-Бүрэн дунд	160,404	110,816	45,311	115,093	-	156,909	3,495	70,620	10,681
-Дунд	27,884	24,543	7,694	20,190	-	26,967	917	6,716	863
-Бага	8,890	8,151	2,095	6,795	-	8,623	267	3,502	55

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурч 2,844,782-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 87.7 хувиар өсөж 788,058-д хүрлээ.

Нийт харилцагчдын 88.4% буюу 2,515,149 нь, зээлдэгчдийн 72.7% буюу 572,668 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 11.6% буюу 329,633, зээлдэгчдийн 27.3% буюу 215,390 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 40,450 буюу нийт харилцагчдын 1.4 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	2019	2020	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	1,042	1,039	4,875	7,712	8,869	1,157	15.0%
Ажилчдын тоо	2,115	2,473	2,784	2,962	3,437	475	16.0%
Харилцагчдын тоо	592,461	1,471,099	1,601,749	2,854,530	2,844,782	(9,748)	-0.3%
Зээлдэгчдийн тоо	102,957	107,442	234,080	419,854	788,058	368,204	87.7%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	4.0%	3.4%	3.3%	3.0%	2.8%	-0.2 пункт	

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн 7,842 буюу 88.4% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,027 буюу 11.6% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	8,869	7,219	2,052	6,817	62	8,685	184	7,842	1,118
Нийт ажилтнуудын тоо	3,437	1,286	2,922	515	119	3,241	196	229	379
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	1,986	695	1,710	276	64	1,849	137	129	202

Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,107 буюу 8.9% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 177 буюу 2.0% нь хөдөө орон нутгийн хувьцаа эзэмшигчид байна.

Хөдөө орон нутгийн 77 ББСБ 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	532	43	517	15	38	455	77	4	528	30
1 Зээл	494	43	479	15	-	419	75	4	490	30
2 Факторингийн үйлчилгээ	34	14	26	8	-	34	-	2	32	2
3 Төлбөрийн баталгаа гаргах	21	7	19	2	-	21	-	1	20	5
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	5	1	1	4	-	5	-	1	4	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	34	11	27	7	-	34	-	2	32	1
6 Гадаад валютын арилжаа	147	25	140	7	38	140	7	3	144	9
7 Итгэлцлийн үйлчилгээ	43	43	36	7	-	42	1	3	40	4
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	11	6	9	2	-	10	1	2	9	2
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	37	17	32	5	-	36	1	4	33	5

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 85.5% буюу 455 ББСБ, салбаруудын 66.8% буюу 197 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 14.5% буюу 77 ББСБ, салбаруудын 33.2% буюу 98 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 1 ББСБ-уудын тархалт



2020 оны жилийн эцсийн байдлаар 76 ББСБ-ын 295 салбар бүртгэлтэй байна. Нийт салбарын 58.2 хувийг 11 ББСБ-ын 166 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн 77	Салбар 98	Нийт 175	Хувь 100%
Архангай аймаг	1	2	3	1.7%
Баян-Өлгий аймаг	3	2	5	2.9%
Баянхонгор аймаг	4	5	9	5.1%
Булган аймаг	2	-	2	1.1%
Говь-Алтай аймаг	1	-	1	0.6%
Говьсүмбэр аймаг	2	2	4	2.3%
Дархан-Уул аймаг	7	11	18	10.3%
Дорноговь аймаг	2	6	8	4.6%
Дорнод аймаг	5	7	12	6.9%
Дундговь аймаг	1	3	4	2.3%
Завхан аймаг	2	2	4	2.3%
Орхон аймаг	7	13	20	11.4%
Өвөрхангай аймаг	7	6	13	7.4%
Өмнөговь аймаг	1	11	12	6.9%
Сүхбаатар аймаг	5	3	8	4.6%
Сэлэнгэ аймаг	5	6	11	6.3%
Төв аймаг	13	3	16	9.1%
Увс аймаг	2	4	6	3.4%
Ховд аймаг	1	3	4	2.3%
Хөвсгөл аймаг	3	5	8	4.6%
Хэнтий аймаг	3	4	7	4.0%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон аймаг, Улаанбаатар хотоос Сүхбаатар дүүрэгт хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн 455	Салбар 197	Нийт 652	Хувь 100%
Сүхбаатар дүүрэг	160	31	191	29.3%
Чингэлтэй дүүрэг	131	29	160	24.5%
Баянгол дүүрэг	74	35	109	16.7%
Баянзүрх дүүрэг	50	47	97	14.9%
Хан-Уул дүүрэг	32	21	53	8.1%
Сонгинохайрхан дүүрэг	7	28	35	5.4%
Багануур дүүрэг	1	4	5	0.8%
Налайх дүүрэг		2	2	0.3%

АКТИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ


2020 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 2.0 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.0 хувиар буюу 276.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Активын өсөлтийн 46.1 хувийг мөнгөн хөрөнгийн өсөлт, 25.5 хувийг цэвэр зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2019 дүн	Нийт дүнд эзлэх хувь	2020 дүн	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,663,005.9	96.1%	1,927,819.7	96.1%	264,813.8	15.9%
Мөнгөн хөрөнгө	363,997.7	21.0%	491,462.7	24.5%	127,465.0	35.0%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	6,752.4	0.4%	11,939.3	0.6%	5,186.9	76.8%
Зээл (цэврээр)	1,151,990.9	66.6%	1,222,582.9	60.9%	70,592.0	6.1%
Нийт зээл	1,233,123.6	71.3%	1,327,028.9	66.1%	93,905.3	7.6%
(Зээлийн эрсдэлийн сан)	81,132.7	4.7%	104,445.9	5.2%	23,313.2	28.7%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	3,805.5	0.2%	3,030.1	0.2%	-775.4	-20.4%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	12,033.1	0.7%	15,048.6	0.7%	3,015.5	25.1%
Бусад хөрөнгө	124,295.7	7.2%	175,207.5	8.7%	50,911.8	41.0%
Санхүүгийн үүсмэл хэрэгсэлийн авлага	-	-	8,548.5	0.4%	8,548.5	-
Эргэлтийн бус хөрөнгө	67,128.2	3.9%	79,071.7	3.9%	11,943.5	17.8%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө	81,287.6	4.7%	101,213.7	5.0%	19,926.1	24.5%
(Хуримтлагдсан элэгдэл)	14,159.4	0.8%	-22,142.0	-1.1%	-36,301.4	-256.4%
Нийт хөрөнгийн дүн	1,730,134.2	100.0%	2,006,891.4	100.0%	276,757.2	16.0%

Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2016 оны мөн үед 787.2 тэрбум төгрөг байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 2.5 дахин өсөж 2.0 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 2.8 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 75.5% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 176 ББСБ, 33.1% нь 2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 356 ББСБ-ын хөрөнгө байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	1,129.9	62	56.3%	11.7%	5.5	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	384.7	114	19.2%	21.4%	5.5	2	4.0	1	-	-
1.9-2.5 тэрбум	225.7	105	11.2%	19.7%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	200.3	124	10.0%	23.3%	1.5	1	3.4	2	1.7	1
0.6-1.4 тэрбум	43.1	39	2.1%	7.3%	5.4	6	6.8	7	3.8	4
0.6 тэрбум хүртэлх	23.1	88	1.2%	16.5%	1.0	3	12.4	50	8.9	33
НИЙТ	2,006.9	532	100.0%	100.0%	18.9	13	26.6	60	14.4	38

Мөнгөн хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн 33.6% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 32.5% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 33.9% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	491.5	127.5	414.7	76.7	13.0	478.9	12.5	38.5	64.7
Бэлэн мөнгө	165.1	7.0	162.2	2.9	10.6	157.9	7.2	0.0	5.7
Харилцах	159.6	44.2	138.9	20.7	2.3	154.7	4.9	13.6	24.3
Хадгаламж	166.8	76.3	113.6	53.2	0.1	166.3	0.5	24.9	34.8

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 33.6%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 3.7%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 81.8% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Сүүлийн 5 жилийн байдлаар активын өсөлтийн дийлэнх хувийг зээлийн үлдэгдэлийн өсөлт бүрдүүлж байсан бол нийт активт эзлэх мөнгөн хөрөнгийн дүн сүүлийн 5 жилийн дундажтай ойролцоо буюу 24.5% байгаа хэдий ч 2020 оны жилийн эцсийн байдлаар активын өсөлтийн 46.1 хувийг мөнгөн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Энэ нь дэлхий дахинд тархаад буй Коронавируст халдварт цар тахал дотоодод тархаж аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хязгаарласантай холбоотойгоор ББСБ-уудын үйл ажиллагааг хумигдсантай холбоотой.

Одоо үйл ажиллагаа эрхэлж буй 532 ББСБ-ын 322 ББСБ-ын мөнгөн хөрөнгийн өсөлт энэ өсөлтийн 129 хувийг бүрдүүлж байгаа нь үүнийг илэрхийлж байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт

Өмнөх оны мөн үеэс активын өсөлтийн хамгийн өндөр өсөлтийн хувийг богино хугацаат хөрөнгө оруулалтын өсөлт үзүүлжээ. Богино хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 76.8% буюу 5.2 тэрбум төгрөгөөр өсч, 2020 оны жилийн эцсийн байдлаар 17 ББСБ 11.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
БХХО(ЦЭВРЭЭР)	11,939.3	10,843.4	9,696.5	2,242.8	1.0	11,266.2	673.2	8,247.0	6,355.9
Хувьцаа	9,755.2	8,704.2	7,512.3	2,242.8	1.0	9,082.0	673.2	7,691.9	5,800.8
Өрийн бичиг	2,179.1	2,139.1	2,179.1	-	-	2,179.1	-	555.1	555.1
Бусад	5.0	-	5.0	-	-	5.0	-	-	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	7,517.7	7,475.9	7,428.7	89.0	-	7,516.7	1.0	5,889.8	5,800.8
Арилжааны үнэт цаас	4,421.6	3,367.5	2,267.8	2,153.8	1.0	3,749.4	672.2	2,357.2	555.1

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 37.0% буюу 4.4 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас, 63.0% буюу 7.5 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 81.7% буюу 9.8 тэрбум төгрөг нь хувьцаа, 18.3% буюу 2.2 тэрбум төгрөг нь өрийн бичгээр, 0.04% буюу 5.0 сая төгрөг нь бусад үнэт цаасаарх хөрөнгө оруулалт байна.

Факторингийн тооцооны авлага

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын тоо нэмэгдсэн хэдий ч 2020 оны жилийн эцсийн байдлаар 6 ББСБ 371.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 57.9 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 3.0 тэрбум төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Факторингийн тусгай зөвшөөрөлтэй 34 ББСБ-уудын 28 ББСБ нь тусгай зөвшөөрөл олгосноос хойш үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 14 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	2019		2020		Өөрчлөлт	
	Нийт дүн	Эзлэх хувь	Нийт дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
	3,855.3	100.0%	3,087.9	100.0%		
Хэвийн	3,709.4	96.2%	2,716.8	88.0%	(992.5)	-26.8%
Хугацаа хэтэрсэн	65.1	1.7%	304.8	9.9%	239.7	368.4%
Чанаргүй	80.8	2.1%	66.3	2.1%	(14.5)	-17.9%
Хэвийн бус	24.7	0.6%	23.8	0.8%	(0.9)	-3.5%
Эргэлзээтэй	31.6	0.8%	11.6	0.4%	(20.0)	-63.2%
Муу	24.5	0.6%	30.8	1.0%	6.3	25.9%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	49.7	1.3%	57.9	1.9%	8.1	16.3%

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 3.0 тэрбум төгрөг буюу 25.1 хувиар өсөж 15.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 15 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	15,048.6	5,194.0	12,443.2	2,605.4	14,928.7	119.9	1,973.7	13,074.9	2,732.3
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	16,620.3	5,580.8	13,882.7	2,737.6	16,503.4	116.9	2,510.2	14,110.2	3,045.6
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	4,166.7	1,410.7	3,971.1	195.7	4,166.7	-	557.8	3,609.0	1,116.5
Өмчлөх бусад хөрөнгө	2,595.0	1,023.9	2,531.6	63.4	2,592.0	3.0	21.3	2,573.7	803.2

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 7.6% буюу 93.9 тэрбум төгрөгөөр өсөж 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,327.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 104.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1,222.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Хүснэгт 16 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	1,222.6	582.8	1,035.9	186.7	1,195.8	26.8	137.7	1,084.9	206.1
Нийт зээл	1,327.0	623.5	1,129.9	197.2	1,294.8	32.2	143.3	1,183.7	218.9
Хэвийн	1,125.7	541.9	948.0	177.7	1,100.7	25.0	134.4	991.3	193.8
Хугацаа хэтэрсэн	64.9	29.0	58.2	6.7	64.0	0.9	1.4	63.5	9.1
Чанаргүй:	136.4	52.6	123.7	12.7	130.1	6.3	7.5	128.9	16.0
-Хэвийн бус	30.3	10.8	28.1	2.1	29.5	0.8	2.0	28.3	4.2
-Эргэлзээтэй	28.7	12.3	25.4	3.4	28.1	0.7	2.4	26.4	3.1
-Муу	77.4	29.5	70.2	7.2	72.5	4.8	3.1	74.3	8.7
(Зээлийн эрсдэлийн сан)	104.4	40.7	93.9	10.5	99.0	5.4	5.6	98.9	12.8
Нийт зээл (төгрөгийн)	1,286.0	599.9	1,094.8	191.3	1,254.2	31.9	130.2	1,155.8	200.1
Нийт зээл (валютын)	41.0	23.6	35.1	5.9	40.7	0.3	13.0	28.0	18.8
Зээлдэгчдийн тоо	788,058	413,644	215,390	572,668	771,267	16,791	236,701	551,357	64,407

/Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно/


2020 онд ББСБ-ууд 1.6 их наяд төгрөгийн зээлийг 2.8 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 1.5 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2020 оны жилийн эцсийн байдлаар 1.3 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Нийт зээлийн үлдэгдлийн 84.8 хувийг буюу 1,125.7 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 4.9 хувийг буюу 64.9 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 10.3 хувийг буюу 136.4 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.2 пунктээр буурсан бол хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.4, 1.7 пунктээр тус тус өссөн байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 201.3 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 51.9%-д буюу 104.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Хүснэгт 17 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/

Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Хэрэглээ	994.3	62.1%	951.5	62.7%	620.5	46.8%
